

Аудитын код: САГ-2018/119/СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn


Ахлах аудитор Д.Цэрэндорж
Утас: 261740 Цахим хаяг: tserendorjd@audit.gov.mn

Аудитор Ц.Энхжаргал
Утас: 261740 Цахим хаяг: enkhjargalts@audit.gov.mn



АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	0
2	Аудитын тайлан	1
2.1	Оршил.....	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	3
2.5	Дотоод хяналт.....	3
2.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	4
2.7	Шилэн дансны мэдээлэл	4
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар.....	4
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	5
2.9.1	Санхүүгийн тайлагналын талаар.....	5
2.9.2	Үндсэн хөрөнгийн талаар	5
2.9.3	Мөнгөн хөрөнгийн талаар.....	6
2.9.4	Бараа материалын талаар.....	7
2.9.5	Зардлын талаар	8
2.9.6	Орлогын талаар	8
2.9.7	Өглөг авлагын талаар.....	8
2.9.8	Буцалтгүй тусламжийн талаар	9
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	9
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	9
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:	10
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11
3.1	Мөнгөн хөрөнгийн талаар.....	12
3.2	Бараа материалын талаар	13
3.3	Өглөг, Авлагын талаар.....	14
3.4	Орлогын талаар.....	14
Аудитаар илэрсэн зөрчлийг удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.....		14
3.5	Зардлын талаар.....	15





**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Л.ЦЭДЭВСҮРЭН
ТАНАА

2018.02.23 № 06/409
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын Яамны 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Сөрөг санал дүгнэлт


Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг үнэлж, Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын Яамны 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлээгүй гэж дүгнэн сөрөг санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын Яамны 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



Аудитын гол асуудал

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын Яамны санхүүгийн тайланд

- 2013, 2014 онуудад яамны хөрөнгө оруулалт, гадаадын зээл, тусламжаар бэлтгэсэн гэх 13,008,535.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг тушаал, шийдвэргүйгээр оны эцэст шилжүүлэн авсан ба дээрх хугацаанд үндсэн хөрөнгөнд элэгдэл байгуулсан эсэх нь тодорхой бус,
- 1,078,858.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг актлахад 1,076,645.7 мянган төгрөгийн зөрчил гаргасан,
- 260,587.0 мянган төгрөгийн мөнгөн гүйлгээний анхан шатны баримт бүрдэл хангалтгүй, бараа материалыг шууд зардалд бичсэн,
- Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар тэтгэмж, урамшууллыг дотоод журмаар тогтоосон хэмжээнээс 52,734.6 мянган төгрөгөөр хэтрүүлсэн,
- бараа материалын тайлан бэлтгээгүй, шууд зардлаар тайлагнасан, шатахуун зарцуулалтын тооцоо хийгээгүй 131,706.2 мянган төгрөг,
- 21,257.9 мянган төгрөгийн зардлыг зардал хооронд гүйлгэн тайлагнасан,
- 60,523.8 мянган төгрөгийн хоорондын тооцоог зардлаар бүртгэсэн,
- цалингийн зардлыг 1,808.6 мянган төгрөгөөр бууруулан бичсэн,
- туслах үйл ажиллагааны орлого 48,863.3 мянган төгрөгтэй холбогдон гарсан зардлыг тусад нь бүртгэл хөтлөөгүй,
- 17,690.4 мянган төгрөгийн авлага, 11,561.6 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй,
- орлого үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангаас 23,031.6 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, иж бүрэн байх, хэмжилт, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.


Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 ОРШИЛ

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын Яамны 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын Яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Цэдэвсүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн авлага, өр төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулах, мөнгөн хөрөнгийн анхан шатны баримтын бүрдлийг хангах, бараа материалыг шууд зардалд бичихгүй байх, туслах үйл ажиллагааны орлоготой холбогдон гарсан зардлыг тусад нь бүртгэл хөтлөх, зардлыг ангиллын дагуу бүртгэх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын Яамны 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын Яамны 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 29-нээс 2018 оны 2 дугаар сарын 5-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 2 дугаар сарын 23-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Д.Цэрэндорж, аудитор Ц.Энхжаргал нар хариуцаж хэрэгжүүлэв.

Аудитаар Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын Яамны 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын Яамны 2018 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 2/888 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт хуулиар тогтоосон хугацааг нэг хоногоор хожимдуулан ирүүлсэн байна.

2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын Яам санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, “Эдийн засгийн ангилал батлах тухай” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

“Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого”, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай” Засгийн газрын 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 3 дугаар тогтоолын дагуу Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын Яамны зохион байгуулалтын бүтцийг баталж үйл ажиллагаагаа явуулж байна.

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын Яамны үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл:

- сургуулийн өмнөх болон бага, дунд, дээд боловсролын сургалтын чанарыг дээшлүүлэх, өрсөлдөх чадвартай хүний нөөц бэлтгэх, багш бэлтгэх тогтолцоог хөгжүүлэх;
- боловсролын чанар, хүртээмж, өрсөлдөх чадварыг сайжруулах, насан туршийн боловсролын тогтолцоог хөгжүүлэх;
- боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн бодлогыг шинэчлэх, өргөжүүлэх;
- шинжлэх ухаан, технологи, инновацийн хөгжлийн бодлого, судалгааны боловсруулалтын ажлын нийгэм, эдийн засгийн үр нөлөөг дээшлүүлж, улс орны хөгжил, нийгмийн сайн сайханд чиглүүлэх;
- хувь хүний хөгжил, нийтийн соёлыг дэмжсэн соёл, урлагийн олон талт үйлчилгээг нийгэмд хүртээмжтэй хүргэж чадахуйц өрсөлдөх чадвар бүхий тогтвортой, хариуцлагатай, үр ашигтай үндэсний үйлчилгээний тогтолцоог соёлын өвийн хамгаалал, соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бэхжүүлэх;
- судалгаанд суурилсан биеийн тамир, спортын олон талт үйлчилгээг нийгэмд хүртээмжтэй хүргэж чадахуйц өрсөлдөх чадвар бүхий тогтвортой, хариуцлагатай, үр ашигтай үндэсний биеийн тамирын үйлчилгээний тогтолцоог хөгжүүлэх, бэхжүүлэх;
- салбарын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд эрх зүйн дэмжлэг үзүүлэх, боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын удирдлагын манлайллыг хангах, яамны төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын чадавхийг сайжруулах, байгууллагын соёл төлөвшүүлэх, салбарын мэдээллийн нэгдсэн санг хөгжүүлэх;

- боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын болон яамны үйл ажиллагааны дотоод аудит, хяналт-шинжилгээ үнэлгээг чанаржуулах, эрсдлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, боловсролын хяналтыг хяналт-шинжилгээ, тандалт, судалгаа хийх хэлбэрээр хэрэгжүүлэх;

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын Яамны эрхэм зорилго нь хөгжлийн чиг хандлага, нийгэм, соёлын үнэт зүйл, хэрэгцээнд нийцүүлэн боловсрол, соёл, шинжлэх ухаан, биеийн тамир, спортын салбарын бодлогын үр нөлөөг дээшлүүлэн олон талт, тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг хэрэгжүүлэх замаар оюуны өндөр боловсрол, ёс суртахууны төлөвшилтэй, эрүүл чийрэг, өрсөлдөх чадвартай хүний нөөцийг бэлтгэх, хөгжүүлэхэд оршино.

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын Яамны үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын Яамны 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 9 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 50 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.


Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын Яамны санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын Яам нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн “асолус” програм хангамжаар бэлтгэсэн байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яамны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хангалтгүй гэж үзлээ.



2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яамны 5 хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг баталгаажуулжээ.

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж урсгал зардалд дээрх хуулиар 2,602,764.8 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 2,472,829.0 мянган төгрөг буюу 95.0 хувьтай байгаа нь туслах үйл ажиллагааны орлого тасарсан, зарцуулах эрх нээгдээгүйн улмаас дутуу санхүүжүүлснээс шалтгаалжээ.

Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг орлого, зардлын ангилал тус бүрээр аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд дэлгэрэнгүй харуулсан бөгөөд туслах үйл ажиллагааны орлого 70,164.6 мянган төгрөгөөр тасарсан, улсын төсвийн санхүүжилт 59,771.1 мянган төгрөгөөр дутуу санхүүжигдсэн байна.

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 76,312.0 мянган төгрөг буюу 19.1 хувиар, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 28,034.9 мянган төгрөг буюу 15.3 хувиар, урсгал шилжүүлэг 24,726.2 мянган төгрөг буюу 10.8 хувиар, үндсэн цалин 476.7 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 275.6 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 94.0 мянган төгрөг, бараа, үйлчилгээний бусад зардал 8.4 мянган төгрөг, томилолт, зочны зардал 8.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яамны мэргэжилтэн, албан хаагч нарт шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх чиглэл, аргачлал мэдээллийг цахим майлээр сар тутам байнга хүргүүлж ажилласнаас гадна Үндэсний Аудитын газраас шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, зөвлөгөө өгөх ажил хийгдсэн байна.

2017 оны III улирлын шилэн дансны тайланг нэгтгэн Үндэсний Аудитын газарт цахимаар илгээсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яамны шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийг Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу байршуулан ажилласан байна.

Тайлант хугацаанд шилэн дансны мэдээллийг ангилан цахим хуудсанд байршуулсан ба нийт 122 мэдээлэл оруулснаас хугацаандаа оруулсан 111, хугацаа хоцорсон 11 мэдээлэл байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 9 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 50 нарийвчилсан горим сорилт гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Санхүүгийн тайлагналын талаар

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яамны 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хугацаа хоцроож, төсвийн гүйцэтгэлийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тохируулгын тайлан, санхүүгийн тайлангийн тодруулга зэргийг тайлангийн хамтаар ирүүлээгүй байна.

Орлого үр дүнгийн тайлан мөнгөн гүйлгээний тайлангаас 23,031.6 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д “төсвийн шууд захирагч ... жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж ...”,

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн “Нягтлан бодох бүртгэлийн зарчим”, 5.1.3-т “жинхэнэ хэрэгжилтийн”, 5.1.4-т “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, 8.1.5-д “санхүүгийн тайлангийн тодруулга”, 8.4-т “... гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна”, 20 дугаар зүйлийн 20.2.9-т “аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг ... үнэн, зөв мэдээллээр хангах ...”,

УСНББОУС-1 стандартын санхүүгийн тайлагналын чанарын шинжүүд хавсралт А-д “Нягтлан бодох бүртгэлийн бодлого түүний чанарын шинж төрх байдлыг багтаасан байгууллагын мэдээллийг танилцуулах шаардлагыг энэ стандартын 29 дүгээр зүйлд тусгасан”,


Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлангийн тэмдэглэл тодруулга нь санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлангийн нүүрний хэсэгт харуулсан дүнгүүдийн талаар хүүрнэсэн тодорхойлолт, эсвэл нэлээд дэлгэрэнгүй жагсаалт буюу судалгаа, мөн болзошгүй өр төлбөр болон амлалт гэх мэт нэмэлт мэдээллийг багтаана” 8.4-д “жилийн эцсийн санхүүгийн тайлан бүрэн тодруулгатай, улирлын тайлан зөвхөн өр авлагын талаар тодруулгатай байна” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтыг бүрэн хэрэгжүүлж, санхүүгийн тайланг хуулийн хугацаанд, тайлбар тодруулгатай бүрэн ирүүлж хэвших, холбогдох ажилтанд хариуцлага тооцох, албан шаардлага хүргүүлэх;

2.9.2 Үндсэн хөрөнгийн талаар

ШУТИС-ийн Эрдэмнэт сүлжээний төвд ашиглагдаж байсан 13,008,535.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг тушаал, шийдвэргүйгээр өны эцэст шилжүүлэн авсан байна. Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын Яамны 2017 оны санхүүгийн тайлан дах үндсэн хөрөнгийн тодруулгаар Төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн /2013, 2014 онд яамны хөрөнгө оруулалтаар гэх/ 1,702,776.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, гадаадын зээл, тусламжаар бэлтгэсэн 6,280,909.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 5,024,850.2 мянган төгрөгийн програм хангамж нийт 13,008,535.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэсэн байна. Дээрх 13,808,535.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөнд элэгдэл байгуулаагүй, эд хариуцагчдын эд хөрөнгийн бүртгэл, бүртгэлийн



дугаарлалт байхгүй, техник ашиглалтын паспорт хөтлөгдөөгүй зэрэг зөрчлүүд илэрсэн.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А-5/3775 тоот албан бичгээр 101 нэр төрлийн 1,078,858.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг актлах зөвшөөрөл олгосон ба актлахад дараах зөрчлүүд илэрсэн.

- ✓ Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд байхгүй 5 нэрийн 1,895.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 463.5 мянган төгрөгийн тавилга эд хогшил, нийт 2,359.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг А-5/3775 тоот бичгийн хавсралтаар акталсан,
- ✓ 64,193.8 мянган төгрөгийн эд хогшил тавилгыг, тоног төхөөрөмж гэж буруу ангилан бүртгэсэн,
- ✓ Тоног төхөөрөмжийн бүртгэлд олон нэр төрлийн тоног төхөөрөмжийг нэг нэрээр бөөндөж зарлага гаргасан. Тухайлбал,
 - хурлын заалны төхөөрөмж 17 нэр төрлийн 384,497.9 мянган төгрөг,
 - тоног төхөөрөмж 5 нэр төрлийн 64,193.8 мянган төгрөг,
 - аймгуудын тоног төхөөрөмж 7 нэр төрлийн 552,483.7 мянган төгрөг,
- ✓ Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлээс 8,917.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хэрхэн зарлага гаргасан нь тодорхойгүй байна. Тухайлбал:
 - 4 нэрийн 6,855.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж,
 - 6 нэр төрлийн 2,061.7 мянган төгрөгийн тавилга эд хогшил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “ерөнхий нягтлан бодогч ...”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, ... ажлыг зохион байгуулах, удирдах”, 20.2.9-д “аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон ... үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах”,

”Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх” журмын 1.2-т “... эд хөрөнгө ... акталж данснаас хасах, шилжүүлэх тухай саналаа ... Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ”,


БСШУССайдын А/40 дүгээр тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 3.1.6-д “... үндсэн хөрөнгийн карт хөтөлнө, ... үндсэн хөрөнгийн ... тайланг улирал бүр гаргаж, ... тайланг гаргуулан хянаж,...” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Санхүүгийн тайлангийн оршин байх, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ”Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх” журмыг мөрдөж ажиллах, албан шаардлага хүргүүлэх;

2.9.3 Мөнгөн хөрөнгийн талаар

2017 оны мөнгөн хөрөнгийн гүйлгээнд 282,187.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд: Үр дүнгийн урамшууллын 114,654.7 мянга, тэтгэмж буцалтгүй тусламжийн 70,078.2 мянга, мөнгөн шагналын 21,600.0 мянга, бараа материалын 18,831.2 мянга, цалин, ажлын хөлсний 18,424.6 мянга, томилолтын тооцооны 15,386.9 мянга, бусад 23,211.4 мянган төгрөгийн анхан шатны баримт бүрдэл хангалтгүй, ебаримт-ыг хавсаргаагүй, баримтыг хувь хүнээр бүрдүүлсэн, бараа материалыг шууд зардалд бичсэн, цохолтгүйгээр гүйлгээ хийсэн, үр дүнгийн гэрээний урамшуулал, буцалтгүй тусламж, эмчилгээний зардлын холбогдох баримтгүй байна. 2017 оны 12 дугаар сарын 1-нээс аж ахуйн няравгүйгээр ажиллаж байна.



Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “... байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө”, 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”,

Төрийн албаны тухай хуулийн 27.1.8-д “... эмнэлгийн байгууллагын шийдвэрээр гадаад оронд эмчлүүлэх ... тохиолдолд зардлынх нь 60-аас доошгүй хувийг төр хариуцах”,

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.4-т “... бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх ... этгээдийг ... сонгон шалгаруулалтын аргаар сонгох”,

БСШУСЯамны Хөдөлмөрийн дотоод журмын 5.8-д “Албан хаагч нь ... суралцах асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд ... хүсэлт гарган шийдвэрлүүлэх”, 9.5-д “... эмчилгээний зардалд зориулан 1.5 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний ..., гэр бүлийн амьдралд ... зориулж 2 сарын үндсэн цалинтай тэнцэх мөнгөн дэмжлэг”,

Төрийн албаны зөвлөлийн “Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам”-ын 6.7-д “Гэрээний биелэлтийг дүгнэх “Илтгэх хуудас”-нд талууд тус тусын гарын үсэг зурж, ... албажуулснаар хүчин төгөлдөр болно”, 7.1-д “А,В үнэлгээ мөнгөн болон бусад хэлбэрийн шагнал олгох саналаа тавьж болно” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн албаны тухай, Төсвийн тухай хуулиуд болон Төрийн албаны зөвлөлийн “Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам”, БСШУСЯамны Хөдөлмөрийн дотоод журмыг дагаж мөрдөж, анхан шатны баримтыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэлд тусгаж ажиллах зөвлөмж хүргүүлэх;

2.9.4 Бараа материалын талаар

2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаарх 95,218.5 мянган төгрөгийн бараа материалын тайлан бэлтгээгүй,

Бэлэн мөнгөөр худалдан авсан 12,552.8 мянган төгрөгийн бараа материалыг шууд зардалд бичсэн,

Жолоочийн хүлээн авсан 23,934.9 мянган төгрөгийн шатахуун зарцуулалтын тооцоо хийгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “... байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө”, 20 дугаар зүйлийн 20.2-т “ерөнхий нягтлан бодогч ...”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, ... ажлыг зохион байгуулах, удирдах”,

БСШУССайдын 2017 оны А/40 дүгээр тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 3.1.4-т “Бараа материалын бүртгэл”-д Хариуцсан нягтлан бодогч нь сар бүрийн материалын тайлангийн орлого талыг мөнгөн хөрөнгийн тайлантай тулгаж шалгана. ... тайлант хугацааны эцэст хариуцсан хөрөнгийн нягтлан бодогчид бараа материалын нэр төрлийн болон үнийн дүнгийн тайлан гаргана” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон БСШУССайдын 2017 оны А/40 дүгээр тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллах зөвлөмж хүргүүлэх;

2.9.5 Зардлын талаар

Торгууль, цайны зардал, машины татвар оношлогоо, тос солих үйлчилгээ, зочин төлөөлөгч хүлээн авах зэрэг 21,257.9 мянган төгрөгийн зардлыг бичиг хэргийн зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, тээвэр шатахуун, бараа үйлчилгээний зардал дансанд бүртгэсэн. Үүнээс: Бичиг хэргийн зардал дансанд 1,031.8 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ дансанд 341.2 мянга, тээвэр шатахуунд 613.4 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 16,321.5 мянга, БҮТЭЗ-д 2,950.0 мянган төгрөгийн зардал бичжээ.

2017 оны 12 дугаар сард Шинжлэх ухааны академид шилжүүлсэн 60,523.8 мянган төгрөгийг хоорондын тооцоо үүсгэлгүй судалгааны ажлын зардалд бүртгэсэн, цалингийн зардлыг 1,808.6 мянган төгрөгөөр бууруулах бичилт хийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”,

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 22 дугаар зүйлийн 22.5-д “төсвийн ангиллын зүйлд санаатайгаар буруу мэдээлэл оруулж, төсвийн орлого зарлагын хэмжээг өөрчлөхийг хориглоно”, 22.6.7-д “төсвийн шууд захирагч нь батлагдсан төсвийг энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар бүртгэж, тайлагнах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хуулиудыг хэрэгжүүлж, зардлыг эдийн засгийн ангиллын дагуу бүртгэж, тайлагнаж хэвших, зөвлөмж хүргүүлэх;

2.9.6 Орлогын талаар

Туслах үйл ажиллагааны орлого 48,863.3 мянган төгрөгтэй холбогдон гарсан зардлыг тусад нь бүртгэл хөтлөөгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3-т “Үндсэн үйл ажиллагааны зардлаас туслах үйл ажиллагаанд зориулж шууд болон шууд бусаар хөрөнгө зарцуулахыг хориглоно”, 44.5-д “Туслах үйл ажиллагааны үр дүнд бий болох ашгийг ...” гэж заасныг хянах боломжгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж, үндсэн үйл ажиллагаа, туслах үйл ажиллагааны зардлын бүртгэлийг тусад нь хөтлөх, зөвлөмж хүргүүлэх;

2.9.7 Өглөг авлагын талаар

2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 17,690.4 мянган төгрөгийн авлага, 11,561.6 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна. Соёлын яамнаас 1995-1997 онуудад олгогдсон зээлийн үлдэгдэл 12,799.0 мянга, 2014 онд үүссэн 4,891.4 мянга, нийт 17,690.4 мянган төгрөгийн авлагыг барагдуулах ажил хийгдээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д “ дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах ... ”, 20.2.6-д “... бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”,

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Санхүүгийн тайлангийн оршин байх, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн хуулийг хэрэгжүүлж, өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, өр төлбөр үүсгэхгүй байх, зөвлөмж хүргүүлэх;

2.9.8 Буцалтгүй тусламжийн талаар

Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар

- ✓ Б/189 тоот тушаалаар нэр бүхий 23 ажиллагсад буцалтгүй тусламж олгосноос Яамны дотоод журмаар тогтоосон хэмжээг 29,190.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн олгосон,
- ✓ Б/143 тоот тушаалаар мэргэжилтэн Гульфирад эмчилгээний зардалд 733.8 мянган төгрөг, Б/189 тоот тушаалаар гэр бүлийг дэмжихэд 1,100.8 мянган төгрөгийг олгосон,
- ✓ Б/196, 202 тоот тушаалаар 550.0 мянган төгрөгийн мөнгөн шагнал олгохоос 110.0 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”,

БСШУСЯамны Хөдөлмөрийн дотоод журмын 5.8-д “Албан хаагч нь ... суралцах асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд ... хүсэлт гарган шийдвэрлүүлэх”, 9.5-д “... эмчилгээний зардалд зориулан 1.5 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний ..., гэр бүлийн амьдралд ... зориулж 2 сарын үндсэн цалинтай тэнцэх мөнгөн дэмжлэг” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж, БСШУСЯамны Хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөж ажиллах, албан шаардлага хүргүүлэх;

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын Яамны 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад ШУТИС-ийн Эрдэмнэт сүлжээний төвд ашиглагдаж байсан 13,008,535.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг тушаал, шийдвэргүйгээр оны эцэст шилжүүлсэн, Сайдын хөтөлбөр арга хэмжээний зардлыг оны эхний 4 сард яамны санхүүгийн тайланд тайлагнасан, үндсэн хөрөнгө, цалингийн тооцоолол зэргийг анхаарч нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын Яамны 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 14,714,946.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 16,493.8 мянган төгрөгийн төлбөрийн акт, 14,227,996.7 мянган төгрөгийн албан шаардлага тогтоож, 470,455.5 мянган төгрөгийн 5 зөвлөмж өгсөн.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын Яамны 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар 4 зөвлөмж өгөгдсөн ба зөвлөмжийн биелэлт хангалтгүй байна.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын Яамны 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,617,633.8 мянган төгрөг бөгөөд 1.0 хувь буюу 36,176.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын Яамны 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын Яамны санхүүгийн тайланд

- 2013, 2014 онуудад яамны хөрөнгө оруулалт, гадаадын зээл, тусламжаар бэлтгэсэн гэх 13,008,535.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг тушаал, шийдвэргүйгээр оны эцэст шилжүүлэн авсан ба дээрх хугацаанд үндсэн хөрөнгөнд элэгдэл байгуулсан эсэх нь тодорхой бус;
- 1,078,858.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг актлахдаа 1,076,645.7 мянган төгрөгийн зөрчилтэй;
- 260,587.0 мянган төгрөгийн мөнгөн гүйлгээний анхан шатны баримт бүрдэл хангалтгүй, бараа материалыг шууд зардалд бичсэн;
- Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар тэтгэмж, урамшууллыг дотоод журмаар тогтоосон хэмжээнээс 52,734.6 мянган төгрөгөөр хэтрүүлсэн;
- бараа материалын тайлан бэлтгээгүй, шууд зардлаар тайлагнасан, шатахуун зарцуулалтын тооцоо хийгээгүй 131,706.2 мянган төгрөг;
- 21,257.9 мянган төгрөгийн зардлыг зардал хооронд гүйлгэн тайлагнасан;
- 60,523.8 мянган төгрөгийн хоорондын тооцоог зардлаар бүртгэсэн;
- цалингийн зардлыг 1,808.6 мянган төгрөгөөр бууруулан бичсэн;
- туслах үйл ажиллагааны орлого 48,863.3 мянган төгрөгтэй холбогдон гарсан зардлыг тусад нь бүртгэл хөтлөөгүй;
- 17,690.4 мянган төгрөгийн авлага, 11,561.6 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй;
- орлого үр дүнгийн тайланг мөнгөн гүйлгээний тайлангаас 23,031.6 мянган төгрөгөөр илүү илэрхийлж санхүүгийн тайланд тус тус тусгасан байна.

Энэ нь УСНББОУС болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцээгүй байна.

Иймд дээр дурдсан алдаа зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийг эс тооцвол Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яамны 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлээгүй гэж дүгнэн “Сөрөг” санал дүгнэлт гаргалаа.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын Яамны нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



3.1 Мөнгөн хөрөнгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

Мөнгөн хөрөнгийн гүйлгээг түүвэрлэн шалгахад 282,187.0 мянган төгрөгийн анхан шатны баримт бүрдэл хангалтгүй, ebarimt-ийг хавсаргаагүй, баримтыг хувь хүнээр бүрдүүлсэн, бараа материалыг шууд зардалд бичсэн, цохолтгүйгээр гүйлгээ хийсэн, үр дүнгийн урамшуулал, тэтгэмж, буцалтгүй тусламжийг холбогдох баримт материалгүйгээр олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "... нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн албаны зөвлөлийн "Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам"-ын 6.7-д "Гэрээний биелэлтийг ... албажуулснаар хүчин төгөлдөр болно", БСШУСЯамны Хөдөлмөрийн дотоод журмын 9.5-д "эмчилгээний зардалд зориулан 1.5 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний, ... гэр бүлийн ... амьдралд зориулж 2 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Зардалд бүртгэлээр тавих хяналт сулрах, үргүй зардал гарах, санхүүгийн тайланг буруу тайлагнах, хөдөлмөрийн дотоод журам зөрчигдөх;

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хуулиуд болон БСШУСЯамны Хөдөлмөрийн дотоод журмыг дагаж мөрдөж ажиллах,

Анхан шатны баримтыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэлд тусгаж ажиллах;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



3.2 Бараа материалын талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

2017 оны жилийн эцэст 95,218.5 мянган төгрөгийн бараа материалын тайлан бэлтгээгүй, худалдан авсан 12,552.8 мянган төгрөгийн бараа материалыг шууд зардалд бүртгэсэн, 23,934.9 мянган төгрөгийн шатахуун зарцуулалтын тооцоо хийгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "... байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", 20 дугаар зүйлийн 20.2-т "ерөнхий нягтлан бодогч ...", 20.2.6-д "эд хөрөнгийн ... тооцооны тооллого хийх, ... ажлыг зохион байгуулах, удирдах", БСШУССайдын А/40 дүгээр тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 3.1.4-т Бараа материалын бүртгэлийн "... тайлант хугацааны эцэст хариуцсан ... нягтлан бодогчид бараа материалын ... тайлан гаргана" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Бараа материалд бүртгэлээр тавих хяналт сулрах, бараа материал үрэгдэх, санхүүгийн тайланг буруу тайлагнах;

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай, БСШУССайдын А/40 дүгээр тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг дагаж мөрдөж ажиллах;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



3.3 Өглөг, Авлагын талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 17,690.4 мянган төгрөгийн авлага, 11,561.6 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна. 1995-1997 онуудад олгосон зээл 12,799.0 мянга, 2014 оны 4,891.4 мянган төгрөгийн авлагыг барагдуулах ажил хийгдээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас өмнө хянан баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Өглөг, авлага баталгаажихгүй байх, санхүүгийн тайланг буруу илэрхийлэх,

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хуулиудыг дагаж мөрдөж ажиллах;

Өглөг, авлагыг тооцоо нийлж, актаар баталгаажуулах,

Авлага, өр төлбөр үүсгэхгүй байх;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

3.4 Орлогын талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

2017 онд туслах үйл ажиллагааны орлого 48,863.3 мянган төгрөг байгаагаас туслах үйл ажиллагааны зардлын бүртгэлийг хөтлөөгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3-т “Үндсэн үйл ажиллагааны зардлаас туслах үйл ажиллагаанд зориулж шууд болон шууд бусаар хөрөнгө зарцуулахыг хориглоно”, 44.5-д “Туслах үйл ажиллагааны үр дүнд бий болох ашгийг...” гэж заасныг хянах боломжгүй байна.


Эрсдэлүүд

Туслах үйл ажиллагааны зардалд бүртгэлээр тавих хяналт сулрах, үндсэн үйл ажиллагааны зардлаас зарцуулах, туслах үйл ажиллагааны үр дүнг буруу тооцоолох;

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;



Аудитаар илэрсэн зөрчлийг удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

3.5 Зардлын талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

БҮТЭЗ, автомашины татвар, оношлогоо, засвар үйлчилгээ, зочин төлөөлөгч хүлээн авах зэрэг 21,257.9 мянган төгрөгийн зардлыг бичиг хэрэг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, шатахуун, бараа ажил үйлчилгээний зардал дансанд бүртгэсэн, Шинжлэх ухааны академид шилжүүлсэн 60,523.8 мянган төгрөгийг шууд зардалд бүртгэсэн, цалингийн зардлыг 1,808.6 мянган төгрөгөөр бууруулах бичилт хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь ... санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.9-т “аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг ... үнэн, зөв мэдээллээр хангах ...”, Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5-д “төсвийн ангиллын зүйлд санаатайгаар буруу мэдээлэл оруулж, төсвийн орлого зарлагын хэмжээг өөрчлөхийг хориглоно”, 22.6.7-д “төсвийн шууд захирагч нь батлагдсан төсвийг энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар бүртгэж, тайлагнах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Зардалд бүртгэлээр тавих хяналт сулрах, зардлын ангиллыг зөрүүтэй бүртгэх, үргүй зардал гарах, санхүүгийн тайланг буруу тайлагнах,

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хуулиудыг дагаж мөрдөж ажиллах,

Батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу бүртгэж, тайлагнах;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

